

Өмнөговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАЛАНЗАДГАД СУМЫН 2017-2020 ОНУУДЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТ
ТҮҮНИЙ ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ӨМА-2021/100-ШТА-ГА

Өмнөговь дахь Төрийн аудитын
газрын дарга, Тэргүүлэх аудиторын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
С.Цэрэнбаяр
Утас: 70533539

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
umnugovi@audit.gov.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
	Дүрслэлийн товъёг	6-7
	<u>Бүлэг 1.</u>	8-10
Дарга, Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цэрэнбаяр	Хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг үндэслэлтэй боловсруулаагүй байна.	
	<u>Бүлэг 2.</u>	11-20
Аудитын менежер Т.Хонгорзул	Гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.	
	<u>Бүлэг 3</u>	21-25
Ахлах аудитор Г.Шижирболд	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт сул байна.	
Аудитор Ч.Наранбадрах Э.Жаргал Т.Хишигбат	<u>Бүлэг 4</u>	26-27
	Явган зорчигч, дугуйн зам зураг төсвийн дагуу хийгдсэн байна.	
	Дүгнэлт	28
	Зөвлөмж	29
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533552 дугаарын утсаар харилцана уу.	Тайлан баталгаажуулсан тушаал	30
ХАЯГ:		
Нутгийн удирдлагын ордон, 303 тоот		
2021 оны 6 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС	
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОНТХ	Орон нутгийн төсвийн хөрөнгө
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу “Даланзадгад сумын 2017-2020 онуудын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт түүний үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлтээ.

Аудитын зорилт:

Даланзадгад сумын 2017-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Даланзадгад сумын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй боловсруулж батлуулсан эсэх;
- ❖ Даланзадгад сумын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх;
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт санхүүжилт үр нөлөөтэй, үр ашигтай эсэх;
- ❖ Даланзадгад суманд хийгдсэн явган зорчигчийн замын бүтээн байгуулалт чанар, үр нөлөөтэй эсэх.

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /тухайн үед мөрдөгдөж байсан/;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;

Аудитын хамарсан хүрээ:

- ✓ Даланзадгад сумын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2016-2020 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2020 онд хэрэгжүүлэхээр 116 төсөл арга хэмжээний төлөвлөлт, сумын хэмжээнд хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, сумын Засаг дарга, холбогдох бусад байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн болно. Даланзадгад суманд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг объект дээр нь очиж үзэн, хэмжилт хийж, зураг төсөвтэй тулгалт хийлээ. Аудитад сумын төсвөөс 2017-2020 онд санхүүжүүлсэн, төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитыг дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цэрэнбаяр хянан удирдаж, Аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Ч.Наранбадрах, Э. Жаргал, Т.Хишигбат нар гүйцэтгэлээ.

Зургийн товч

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сүлдэт майнинг ХХК-ий хийсэн ажлаас. Фасад хуурсан байдал	13
Зураг 2	Барилгын зураг	14
Зураг 3	Хүлээлгэн өгсөн зураг төсөв	14
Зураг 4	Нийлүүлсэн авто машин	15
Зураг 5	Нийлүүлсэн хөрөнгө	16
Зураг 6	Зөрүүтэй нийлүүлэгдсэн авто машины гэрчилгээ	16
Зураг 7	Нийлүүлэгдсэн зарим хөрөнгө	17
Зураг 8	Усны хоолой	17
Зураг 9	Нийлүүлэгдсэн зарим хөрөнгө	18
Зураг 10	Нийлүүлэгдсэн зарим хөрөнгө	19
Зураг 11	Нийлүүлэгдсэн авто машин	19
Зураг 12	Нийлүүлэгдсэн хөрөнгө	20
Зураг 13	Нийлүүлэгдсэн хөрөнгө	20
Зураг 14	Тоглоомын талбай	22
Зураг 15	Худгийн цоож эвдэрсэн байдал	23
Зураг 16	Цахилгааны утас харагдаж байгаа байдал	23
Зураг 17	Худгийн аюулгүй ажиллагаа алдагдсан байдал	23
Зураг 18	Эвдэрсэн гэрлийн шонгийн зураг	24
Зураг 19	Тамхины цэгийн шороо тоос орсон байдал	25
Зураг 20	Анх хүлээж авсан зураг	27
Зураг 21	3 жилийн дараах зураг	27
Зураг 22	Явган хүний замын одоогийн зураг	27

График товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Даланзадгад сумын 2017-2020 онд хийгдэх хөрөнгө оруулалтын эх үүсвэр он тус бүр	8
График 2	Даланзадгад сумын 2017-2020 онд хэрэгжүүлэх төсвийн төрөл	8
График 3	Даланзадгад сумын 2017-2020 онд хийгдэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг он тус бүрээр	10
График 4	Даланзадгад сумын 2017-2020 онд хэрэгжүүлсэн ТАХ-ны төрөл	18

Хүснэгтийн товъёг


№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Үнэлгээний хороонд гурав болон түүнээс дээш орж ажилласан иргэдийн судалгаа	11

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг үндэслэлтэй боловсруулаагүй байна.



Даланзадгад суманд 2017-2020 онд нийт 22,891.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 116 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4,932.3 сая төгрөгийн 82 ТАХ-г орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 17,958.7 сая төгрөгийн 34 ТАХ-г аймгаас эрх шилжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн ТАХ нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан “Үндсэн чиглэл 2017-2020”, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байна.



Дээрх баримт бичгүүдэд ТАХ-г ерөнхий нэрээр тусгасан байгаа боловч Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3 дахь хэсгийн 3.6¹-д заасны дагуу хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлсэн нь нотлогдохгүй байна.

Мөн Даланзадгад суманд урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого байхгүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ үр дүнгүй хэрэгжих, хэрэгцээ шаардлагатай асуудалд чиглэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Иймд аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх шаардлагатай байна.

Даланзадгад суманд 2017 онд аймгаас эрх шилжсэн 985.5 сая төгрөгийн 11 ТАХ, 2018 онд орон нутгийн төсвөөс 1,441.8 сая төгрөгийн 30 ТАХ, эрх шилжсэн 5,542.1 сая төгрөгийн 5 ТАХ, 2019 онд орон нутгийн төсвөөс 1,369.5 сая төгрөгийн 25 ТАХ, эрх шилжсэн 3,562.9 сая төгрөгийн 12


¹ Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалттай харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

ТАХ, 2020 онд орон нутгийн төсвөөс 2,121.0 сая төгрөгийн 27 ТАХ, эрх шилжсэн 7,868.2 сая төгрөгийн 6 ТАХ-г тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

ДАЛАНЗАДГАД СУМЫН 2017 – 2020 ОНД ХИЙДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЭХ
ҮҮСВЭРЭЭР НЬ ОН ТУС БҮРЭЭР ХАРУУЛБАЛ:

График №1

/сая төгрөг/



Эх сурвалж: Даланзадгад сумын 2017-2020 оны тайлан


Дээрх үзүүлэлтээс харахад 2020 онд хамгийн өндөр дүнтэй буюу 9,989.2 сая төгрөгийн 33 ТАХ, 2017 онд хамгийн бага дүнтэй буюу 985.5 сая төгрөгийн 11 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна.

Нийт төсөл арга хэмжээг төрлөөр нь ангилбал гэрэлтүүлэг, цахилгаан эх үүсвэрт 10 ТАХ, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 28 ТАХ, тоног төхөөрөмж худалдан авахад 36 ТАХ, урсгал засварын зардалд 10 ТАХ, худаг, усан хангамж сайжруулахад 6 ТАХ, Автомашин худалдан авахад 12 ТАХ, зураг төсөв боловсруулахад 9 ТАХ, бусад 5 ТАХ-г тус тус төлөвлөсөн байна.

ДАЛАНЗАДГАД СУМЫН 2017 – 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТЛАГДСАН ТӨСВИЙГ
ТӨРЛӨӨР НЬ АНГИЛБАЛ:

График №2

/сая төгрөг/



Эх сурвалж: Даланзадгад сумын 2017-2020 оны тайлан

Үүнээс харахад нийтийн эзэмшлийн талбайд хамгийн их буюу 14,791.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдсан байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад дараах зардлын шинж чанартай хөрөнгийг тусгаж баталсан байна. Тухайлбал:

- Соёл олон нийтийн ажлын хүрээнд "Ботгон тэшээ" бүжгийг дүрсжүүлэхэд 9,9 сая төгрөг,
- Даланзадгад сумын зорилтот бүлгийн өрхөд нүүрс нийлүүлэхэд 49,9 сая төгрөг,
- Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин засварлахад 20,0 сая төгрөг,
- Мал угаалга, хашаа хороо, ариутгал халдваргүйжүүлэлтэд 16,9 сая төгрөг

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24², 58.2³, 58.2.3⁴-т заасантай тус тус нийцэхгүй байна.

² “хөрөнгө оруулалт” гэдэг нь төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

³ Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ

⁴ орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх




БҮЛЭГ 2. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

Даланзадгад суманд ОНТХ-өөр 2017 онд хийгдэх 11 ТАХ төлөвлөснөөс 100%, 2018 онд 35 ТАХ төлөвлөснөөс 100%, 2019 онд 37 ТАХ төлөвлөснөөс 95%, 2020 онд 33 ТАХ төлөвлөснөөс 86%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

ДАЛАНЗАДГАД СУМЫН 2017 – 2020 ОНД ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ОН ТУС БҮРЭЭР ХАРУУЛБАЛ:

График №3

/сая төгрөг/



Эх сурвалж: Даланзадгад сумын 2017-2020 оны тайлан

Дээрх онуудад сумын хэмжээнд нийт 13 ТАХ хэрэгжээгүй байна. Үүний 2019 онд хэрэгжээгүй 2 ТАХ-г аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр болсон бол 2020 оны 11 ТАХ нь эдийн засгийн хүндрэл үүсэж төсөв тасарсны улмаас хэрэгжих боломжгүй болсон байна.

ОНТХ-өөр хэрэгжүүлсэн 103 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулсан бөгөөд 56,3 хувь буюу 58 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 14,6 хувь буюу 15 ажлыг харьцуулалтын аргаар, 29,1 хувь буюу 30 ажлыг шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс 7 тендерт гомдол гарч Сангийн ямаар хянагдсан байна. Мөн 1 тендерийн материал Авлигатай тэмцэх газраар шалгагдаж байна.

Даланзадгад суманд 2017-2020 онуудад хийгдсэн 102 ТАХ-ны тендер шалгаруулалтын хавтаст хэргийг шалгахад бичиг баримтын бүрдэл дутуу, хангалтгүй архивлагдсан байна. Энэ нь "ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2⁵ заасантай нийцэхгүй байна.

⁵ 49.2.Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ:

49.2.1.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар;

49.2.2.нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл;

49.2.3.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг;

49.2.4.захиалагч, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер;

49.2.5.тендерт оролцогчдын ирүүлсэн тендер;

49.2.6.тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж;

49.2.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл;

Аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байж цаашид зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож байх тухай албан шаардлага хүргүүлээ.

Даланзадгад сумын тендер шалгаруулах үнэлгээний хороонд тайлант онд нийт 60 гишүүн орж ажилласны 30 гишүүн нь 3 болон түүнээс олон давтамжтайгаар үнэлгээний хороонд томилогдсон байгаа нь ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэл үүсгэж байна.

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНД ГУРАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ОРЖ АЖИЛЛАСАН
ИРГЭДИЙН СУДАЛГАА**

Хүснэгт №1

№	Нэрс	Албан тушаал	Үнэлгээний хороонд ажилласан тоо
1	Ц.Мөнхзаяа	Байгаль орчин, уул уурхайн бодлогын мэргэжилтэн	30
2	У.Отгонцэцэг	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан бодлогын мэргэжилтэн	25
3	Ч.Лхагвацэрэн	Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	24
4	Д.Отгонбат	Санхүү албаны дарга	21
5	Э.Мөнхболор	Засаг даргын орлогч	17
6	С.Болд	Боловсрол, соёл хариуцсан мэргэжилтэн	17
7	С.Мөнх-Эрдэнэ	Цэрэг онцгой байдал хариуцсан бодлогын мэргэжилтэн	14
8	Ч.Дүүрэнжаргал	Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	14
9	Б.Бямбасайхан	Иргэний төлөөлөл	14
10	Б.Халиун	Хөдөлмөр, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн	12
11	Э.Бямбахүү	Иргэний төлөөлөл	11
12	Ө.Баярхүү	Иргэний төлөөлөл	10
13	П.Дөлгөөн	Засаг даргын туслах /иргэний төлөөлөл/	10
14	Т.Отгонбаатар	Иргэний төлөөлөл	10
15	Б.Дэнсмаа	Иргэний төлөөлөл	9
16	Б.Гэрэлт-Од	Иргэний төлөөлөл	7
17	Б.Пүрэвсүрэн	Нягтлан бодогч /иргэний төлөөлөл/	7
18	Ч.Сугархүү	Иргэний төлөөлөл	7
19	Н.Бадамцэцэг	Иргэний төлөөлөл	7
20	Б.Энхбурам	Архив, бичиг хэргийн эрхлэгч	6
21	Х.Болортуяа	Төрийн сангийн мэргэжилтэн	5
22	Ц.Золбоо	Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн	5
23	Ц.Пүрэвсүрэн	Иргэний төлөөлөл	5
24	Б.Бямбадорж	Иргэний төлөөлөл	4
25	Б.Бямбасүрэн	Иргэний төлөөлөл	4
26	Т.Ууганбаяр	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн	4
27	Ж.Багахүү	Иргэний төлөөлөл	3
28	Ж.Очирхуяг	Иргэний төлөөлөл	3
29	П.Золжаргал	Иргэний төлөөлөл	3
30	С.Нандинцэцэг	Хууль эрхзүй хариуцсан мэргэжилтэн	3

49.2.8.гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ;

49.2.9.тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг;

49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг

Үнэлгээний хороонд иргэний төлөөллөөр Б.Бямбасайхан 14 удаа, Э.Бямбахүү 11 удаа буюу хамгийн олон удаа ажилласан байна. Энэ нь "ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2⁶ заасантай нийцэхгүй, үнэлгээний хороог байнгын шинжтэй болгох эрсдэлийг дагуулж байна. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх тухай зөвлөмж өглөө.

Даланзадгад сумын 2017-2020 онуудад хийгдсэн 39 ТАХ-ний гэрээнд заасан хугацаа хэтэрсэн боловч гэрээний заалтын дагуу алданги тооцож ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3⁷, Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1⁸ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Уг зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээний хэрэгжилтийг тооцож байх албан шаардлагыг хүргүүлээ.

Худалдан авах ажиллагааг нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулсан боловч амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан 12 ТАХ байна. Энэ нь тендерийн зар, зарлал олон нийтэд нээлттэй ил тод хүрээгүй, ТЭЗҮ, техникийн тодорхойлолтыг тооцоо судалгаагүй, хэт өндөр шалгуур тавьсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Даланзадгад сумын 2017-2020 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, ашиглалтын байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд.

Ажлын нэр: Даланзадгад сумын төвийн орон сууцны гаднах нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах /2018 он/

Гүйцэтгэгч: Тэлмүүн доной ХХК, Цэлмэг зам ХХК, Сүлдэт майнинг ХХК

Гэрээний дүн: 2,677.8 сая төгрөг

Зөрчлийн утга: Худалдан авах ажиллагаа зарлахдаа хэт өндөр шалгуур тавьснаас 2 удаа амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан, багц 3 болон 4-т шалгарсан Сүлдэт майнинг ХХК-ыг сонгосон шалтгаан тодорхойгүй, нотлох баримт хангалтгүй, гэрээний хугацаа хэтэрсэн.

Шийдвэрлэсэн байдал: Нөхцөл байдлыг шинжлэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.⁹

Зураг №1 /Сүлдэт майнинг ХХК-ий хийсэн ажлаас. Фасад хуурсан байдал/



⁶ Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх ...

⁷ санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх

⁸ гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх

⁹ Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ

- Ажлын нэр: Хилийн цэргийн 0131-р ангийн офицер, ахлагч нарын орон сууцны байрны урсгал засвар /2018 он/
Гүйцэтгэгч: Говийн арвин ус ХХК
Гэрээний дүн: 50.0 сая төгрөг
Зөрчлийн утга: Тендерийн урилгад БХБЯ-ны Тусгай зөвшөөрөлтэй байхаар заасан боловч шууд гэрээ байгуулахдаа тусгай зөвшөөрөлгүй компанитай гэрээ байгуулсан, барилгын цонхны амлагааг дутуу засварласан, санхүүгийн гүйлгээний баримтад компанийн нэр, тамга зөрүүтэй байна.
Шийдвэрлэсэн байдал: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 12 сарын 22-ны 415 дугаар тушаал "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам"-ыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Зураг №2 /Барилгын зураг/



- Ажлын нэр: Өвсний фондын барилгын зураг төсөв боловсруулах /2018 он/
Гүйцэтгэгч: Жаргалант хийц ХХК
Гэрээний дүн: 27.0 сая төгрөг
Зөрчлийн утга: Зураг төслийн ажлын жишиг үнийг ажлын даалгаврын дагуу тооцоолол хийж үзэхэд $600\text{м}^2 \times 13,378 \text{ төгрөг} = 8,026.800 + 10\% = 8,8 \text{ сая төгрөг}$ болж байна. Харин төсвийг 27.0 сая төгрөгөөр хэт өндөр төсөвлөж гэрээ байгуулсан байна.
Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁰ дэх заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.

Зураг №3 /Хүлээлгэн өгсөн зураг төсөв/



¹⁰ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

- Ажлын нэр: Нийтийн тээврийн зогсоолын засвар шинэчлэл /2018 он/
Гүйцэтгэгч: Тангад Араа ХХК
Гэрээний дүн: 40.0 сая төгрөг
Зөрчлийн утга: Үндсэн чиглэлд суулгасан нэр зориулалтын дагуу ажил хийгээгүй, замын тэмдэг, тэмдэглэгээний ажил хийгдсэн.
Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.5.5¹¹ дахь заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.
- Ажлын нэр: Төрийн үйлчилгээний автомашиныг шинэлэх /2018 он/
Гүйцэтгэгч: Нэмэхт суурь ХХК
Гэрээний дүн: 27.2 сая төгрөг
Зөрчлийн утга: Техникийн тодорхойлолтод toyota landgruise Prado 120 авахаар заасан боловч toyota harrier машин хүлээн авсан байна.
Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2¹² дахь заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.


Зураг № 4 /Нийлүүлсэн авто машины зураг/



- Ажлын нэр: Даланзадгад сум хариуцсан мэргэжилтний техник хэрэгслийг шинэчлэх /2019 он/
Гүйцэтгэгч: Саус гоби компьютерс ХХК
Гэрээний дүн: 9.9 сая төгрөг
Зөрчлийн утга: Улсын бүртгэлийн хэлтэст нийлүүлэгдсэн 9.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тулган баталгаажуулахад хоёр ширхэг сканер нь ижил төстэй бараа бүтээгдэхүүн зарж борлуулдаг гурван дэлгүүрт 0.9-1.6 сая төгрөгийн үнэтэй байтал 4.1 сая төгрөгөөр хэт өндөр үнээр нийлүүлсэн байна.
Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.

¹¹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹² Техникийн тодорхойлолт



- Зураг №6 /Зөрүүтэй нийлүүлэгдсэн авто машины гэрчилгээ/*

ТЕХНИКИЙН ТОДОРХОЛ
Technical description
2009 MY

Улсын дугаар
License plate number
TOYOTA

Марк, модель
Make, Model
Land Cruiser 70

Ангилал, хөдөлгүүрийн багтаамж
Category, Engine displacement
В. 4164

Бүжжйн
Gross vehicle weight rating
Бүжжйн - 2780 кг, Ө жжйн - 2280 кг

Даац/зэглэхүүн/, суудлын тоо
Loading Capacity, Number of Seats
С. 200 - 8

Төрөл
Type
SUV

Зориулалт
Designation
Суудал

Үйлдвэрлэсэн он
Date of manufacture
2016

Хөдөлгүүрийн №
Engine №
JTERB71J900085949

Аралын №
VIN №
Цагаан

Бүжээний №
Color №
Өнгө

Импортлогдсон огноо
Date of import
2016/10/11

Гэрчилгээ олгосон:
/gэмдэг/ /гарын үсэг/
201...оны...р сарын...ны өдөр

(MGL)

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЦАГДАЛГИЙН ГАЗАР

Хаяг
Address
Өмнөговь Даланзадгад Далан
Өвийн бүс 01

ӨӨРЧИЛСЭН ТЭМДЭГЛЭЛ
Revised note

Хөдөлгүүр / Engine	Өнгө / Color
/гэмдэг/ /гарын үсэг/	/гэмдэг/ /гарын үсэг/
201...оны...р сарын...ны өдөр	201...оны...р сарын...ны өдөр

Тусгай тэмдэглэл
Additional note

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ
VEHICLE INSPECTION REPORT

Он, сар, өдөр	Техникийн байдал	Гарын үсэг /гэмдэг/
2019 03 14	<i>Druck</i>	<i>Х.О.Т.Б.З.</i>

(Засвартай бол хувиул)


№ 02290365

- ### Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

мэргэжилтнүүдэд хариуцуулсан суурин 4 ширхэг компьютер, 5 ширхэг Notebook, 1 ширхэг ухаалаг дэлгэц, 1 ширхэг албаны нууцын сейф, нийт 12 ширхэг тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, үзүүлэлтийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.

Зураг №7 /Нийлүүлэгдсэн зарим хөрөнгө/



- **Ажлын нэр:** Сумын онцгой комисст шаардлагатай автомашин, техник хэрэгсэл, эд хогшил нийлүүлэх /2020 он/


Гүйцэтгэгч: Багц-2 Өнөрговь ХХК

Гэрээний дүн: 59.5 сая төгрөг

Зөрчлийн утга: Нийлүүлсэн резинэн усны хоолой ажлын даалгавраар 100 метр байхаас 60 метрийг нийлүүлсэн байна.

Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлээ.

Зураг №8 /Усны хоолой/



- **Ажлын нэр:** 4 дүгээр цэцэрлэгийн барилгын хүчитгэл хийлгэх /2020 он/

Гүйцэтгэгч: Хүслэн хийморь ХХК

Гэрээний дүн: 269.7 сая төгрөг

Зөрчлийн утга: Өгөгдлийн хүснэгт дээрх шаардлагыг хангаагүй компани сонгон шалгаруулсан. /Нийгмийн даатгалын НД8 маягтыг сүүлийн 6 сарын байдлаар ирүүлэх бөгөөд шаардсан инженер техникийн ажилчид сүүлийн 6 сар тухайн байгууллагад ажилласан байх, үндсэн тоног төхөөрөмж, машин механизмын жагсаалт, түрээсийн гэрээ, техник хэрэгслийн гэрчилгээний хуулбар, үндсэн тоног төхөөрөмж дээр ажиллах ажилчдын мэдээлэл ирүүлэх, диплом мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно/

Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5¹³ дахь заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

- **Ажлын нэр:** ЗДТГ-н иргэний танхимыг засварлан тохижуулах, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах /2020 он/

Гүйцэтгэгч: Биндэр алтай оюу ХХК

Гэрээний дүн: 24.9 сая төгрөг

Зөрчлийн утга: Тамгын газрын иргэний танхимыг засварлан тохижуулах, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах багц 2 ажлын хүрээнд нийлүүлсэн 8 ширхэг суурин компьютер, 5 ширхэг зөөврийн компьютер, 8 ширхэг төмөр шкаф нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтээс зөрүүтэй нийлүүлэгдсэн байна. Мөн 8 ширхэг суурин компьютер, 8 ширхэг төмөр шкаф, 5 ширхэг зөөврийн компьютер, 1 ширхэг дэлгэц 50инч, 1 ширхэг компьютерын дэлгэц, оффис ширээ, сканер иргэний танхим хамааралгүй багийн төвүүд болон сумын ЗДТГ-ын албан хаагчид ашиглаж байна.

Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх зөвлөмж өглөө.

Зураг №9 /Нийлүүлэгдсэн зарим хөрөнгө/



- **Ажлын нэр:** Захирагчийн ажлын албаны конторт техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэх /2020 он/

Гүйцэтгэгч: Тэнгэрийн мэлмий ХХК

Гэрээний дүн: 74.7 сая төгрөг

Зөрчлийн утга: Захирагчийн ажлын албаны конторт техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэх ажлын цонхны хөшиг /150*160 хэмжээтэй/ 3 ширхэг дутуу, цонхны хөшиг /150*90 хэмжээтэй/ 3 ширхэг дутуу, хурлын 5 ширхэг заалны ширээ зай талбайг цогц шийдлээр хувьсан өөрчлөгдөх боломжгүй, компьютер, уртасгагчийн залгуур орох нүхгүй, хурлын заалны сандал 100 ширхэг эдэлгээ сайн даах чадваргүй, дээр дээрээс нь тавиад сандлын бүрээс урагдсан, хурлын заалны индрийн хөл нь зөөлөвчгүй, оффис шкафын хөл нь зөөлөвчгүй, архивын нягтруулсан шүүгээ нь цоожлогддоггүй, эйр кондейшн 3ш нь барилгын хана цоолж тогтоох боломжгүй учир ашиглагдахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх албан шаардлага хүргүүлээ.

¹³ “тендерийн баримт бичиг” гэж захиалагчаас тендерт оролцогчид зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон баримт бичгийг

Зураг №10 /Нийлүүлэгдсэн зарим хөрөнгийн зураг/



Ажлын нэр: Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашин нийлүүлэх /2020 он/

Гүйцэтгэгч: Сүүхүнгий ХХК

Гэрээний дүн: 59.7 сая төгрөг

Зөрчлийн утга: Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашин нийлүүлэх ажлын хүрээнд Шим билэг, Өнө-Орших өрхийн эмнэлгүүдэд нийлүүлсэн автомашин нь халуун, хүйтнээр үлээдэггүй шалтгаанаар ашиглагдахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Зураг №11 /Нийлүүлэгдсэн авто машины зураг/



- Ажлын нэр: Сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах /2020 он/

Гүйцэтгэгч: Хайрхан баян бор ХХК

Гэрээний дүн: 77.9 сая төгрөг

Зөрчлийн утга: Ажлын хүрээнд нийлүүлэгдсэн универсал индикатор, ухаалаг самбар, том, жижиг бөмбөг, тайзны хөшиг, лабораторийн сандал, ус нэрэгч, документ камер зэрэг тоног төхөөрөмж нь зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын ажлыг техник эдийн засгийн үндэслэлтэй тооцоолж байх албан шаардлага хүргүүлээ.

Зураг №12 /Нийлүүлэгдсэн хөрөнгийн зураг/



- Ажлын нэр: Цэцэрлэгүүдэд шаардлагатай хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангах /2020 он/

Гүйцэтгэгч: Өнөр говь ХХК

Гэрээний дүн: 51.9 сая төгрөг

Зөрчлийн утга: Ажлын хүрээнд нийлүүлэгдсэн будаа агшаагч 13 литрийн багтаамжтай, 2-р хоолны ган тогоо нийлүүлсэн нь техникийн тодорхойлолтоос зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн байдал: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж ажиллаа.

Зураг №13 /Нийлүүлэгдсэн зарим хөрөнгийн зураг/



Үүнээс харахад захиалагч талаас зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1¹⁴ дэх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тооцож, үр ашиггүй зардал гаргахгүй байх, худалдан авах ажиллагааг хуульд заасан шаардлагуудын дагуу зохион байгуулах, хийгдсэн ажлуудын ашиглалт хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

¹⁴ тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох



БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт сул байна.

Даланзадгад сумын 2017–2020 онуудад гүйцэтгэлээр нийт 21,980.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.


Гэрэлтүүлэг, цахилгаан эх үүсвэрт 2,960.0 сая төгрөг, нийтийн эзэмшлийн гудамж талбайд 14,713.1 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1,485.3 сая төгрөг, урсгал засварт 685.2 сая төгрөг, худаг, усан хангамж сайжруулахад 432.0 сая төгрөг, авто машин худалдан авахад 1,202.0 сая төгрөг, зураг төсөв боловсруулахад 404.9 сая төгрөг, бусад хөрөнгө оруулалтад 196.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийт төлөвлөсөн ажил 88,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДАЛАНЗАДГАД СУМЫН 2017 – 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-Г ТӨРЛӨӨР НЬ
АНГИЛБАЛ:

График №4

/сая төгрөг/



Эх сурвалж: Даланзадгад сумын 2017-2020 оны гүйцэтгэлийн тайлан

Графикаас харахад хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 67 хувийг нийтийн эзэмшлийн талбай барих, тохижуулах ажилд зарцуулсан байна. Харин хамгийн олон удаагийн давтамжтайгаар албан байгууллагуудыг тоног төхөөрөмжөөр хангах ажил 30 хувийг эзэлж байна

ОНТХ оруулалтаар хийгдсэн барилга байгууламж, зам талбайн ажлуудыг аймгийн ГХБХБ-ын газартай гэрээ байгуулан захиалагчийн хяналт хийлгэдэг бол тоног төхөөрөмж болон бусад ажилд СЗДТГ-ын даргын томилсон багийн гишүүд хяналт хийсэн байна.

Аудитын явцад захиалагчийн хяналттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- **Ажлын нэр:** Даланзадгад сумын төвийн орон сууцны гаднах нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажлын Багц 1.2-т захиалагчийн хяналт хийх /2018-2019 он/
Гүйцэтгэгч: "ББУТ констракшн" ХХК
Гэрээний дүн: 11.7 сая төгрөг

Зөрчлийн утга: Даланзадгад сумын төвийн орон сууцны гаднах нийтийн эзэмшлийн талбайн засварын Багц 1-4 ажилд захиалагчийн хяналт хийлгэхээр ГХБХБ-ын газартай гэрээ байгуулсан ч нэмэлтээр Багц-1, Багц-2 ажилд захиалагчийн хяналт хийлгэхээр "ББУТ констракшн" ХХК-тай гэрээ байгуулсан байна. Гэрээнд зааснаар "ББУТ констракшн" ХХК үе шат бүрд хяналт хийхээр заасан боловч үе шатуудад хяналт хийсэн талаарх нотлох баримт материал байхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Дээрх нөхцөл байдлыг шинжлэн үзээд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзээд Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалтын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Төсвийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-н ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна. Тухайлбал:

- **Ажлын нэр:** Даланзадгад сумын орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд тоглоомын талбай байгуулах /2017 он/

Гүйцэтгэгч: “Таянхараан” ХХК

Гэрээний дүн: 288.0 сая төгрөг

Зөрчлийн утга: Хан-уулийн 2-р багт хийгдсэн тоглоомын талбайг засмал зам тавих шалтгаанаар буулгасан боловч шилжүүлэн суулгаагүй. 1 болон 3-8-р багт хийгдсэн тоглоомын талбайд 4 ширхэг сагсны шит, 24 ширхэг сандал, 6 ширхэг сүүдрэвч, 24 ширхэг хогны сав, 9 ширхэг чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, 7 ширхэг элсний сав, талбай, 3 ширхэг төмөр хашаа эвдэрсэн, 13 ширхэг гэрэлтүүлэг дутуу байгаагаас тоглоомын талбайг зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болсон байна.

Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1¹⁵, Барилгын тухай хуулийн 14.7¹⁶, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7¹⁷ дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, гарсан зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлээ.

Зураг №14 /Тоглоомын талбайн зураг/



- **Ажлын нэр:** Төв саадад гүн өрмийн худаг гаргах /2018 он/

Гүйцэтгэгч: “Өбино ХХК

Гэрээний дүн: 32.0 сая төгрөг

¹⁵ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах

¹⁶ Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль бүрүүтэй этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

¹⁷ Ашиглагч барилга байгууламжид хийсэн үзлэгээр илэрсэн эвдрэл гэмтлийг тухай бүр цаг алдахгүй арилгуулах арга хэмжээ авна

Зөрчлийн утга: Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба ашиглаж, өмчилж төв саад, Борын нэрэмжит талбайн ногоон байгууламжийг усалж байгаа бөгөөд ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдсан, цооногт ус дүүрсэн, цоожгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Барилгын тухай хуулийн 14.7, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгах, эвдрэл гэмтлийг засуулах талаар албан шаардлага хүргүүлээ.

Зураг №15 /Худгийн цоож эвдэрсэн/



Зураг №16 /Цахилгааны утас харагдаж байгаа байдал, мөн ус дүүрсэн байна/



Зураг №17 /Худгийн болон гэрэлтүүлгийн цахилгааны ерөнхий самбар , цахилгааны утасны аюулгүй ажиллагаа алдагдсан ус, хөрснөөс тусгаарлах сүвлэгч хийгдээгүй байна/



- **Ажлын нэр:** Т.Борын талбайг засварлан, тохижуулах /2018 он/
Гүйцэтгэгч: Дэт ХХК
Гэрээний дүн: 476.8 сая төгрөг
Зөрчлийн утга: Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба ашиглаж, өмчилж байгаа ба одоогоор ашиглалт хамгаалалт хангалтгүй эвдэрсэн, үсгүүд нь унасан байна.
Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Барилгын тухай хуулийн 14.7, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгах, эвдрэл гэмтлийг засуулах талаар зөвлөмж өглөө.
- **Ажлын нэр:** Сумын төв дотор автозам, авто зогсоол, явган хүний зам, гэрэлтүүлгийг барьж байгуулах /Улаанбаатар чиглэлийн зам - Соёл амралтын хүрээлэн хүртэлх 4.22 км/ /2020 он/
Гүйцэтгэгч: Таны зам ХХК
Гэрээний дүн: 4,464.3 сая төгрөг
Зөрчлийн утга: Уг хийгдсэн ажлын нэг гэрлийн шонг машин мөргөсөн, 3 гэрлийн толгой байхгүй, 4 гэрэл асахгүй байна.
Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Барилгын тухай хуулийн 14.7, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгах, эвдрэл гэмтлийг засуулах талаар зөвлөмж өглөө.

Зураг №18 /Эвдэрсэн гэрлийн шонгийн зураг/



- **Ажлын нэр:** Даланзадгад сумын төвийн автозам болон гэр хорооллыг камержуулах /2018 он/
Гүйцэтгэгч: Ай Ти Зон ХХК
Гэрээний дүн: 942.0 сая төгрөг
Зөрчлийн утга: Шилэн кабелийн шугам, худгийг мэргэжлийн байгууллагад хүлээлгэж өгөөгүй тул засвар үйлчилгээ, тохируулгыг Цагдаагийн газар хийх боломжгүй байна.
Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 заалтыг хэрэгжүүлж ажиллах, үүссэн нөхцөл байдалд арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өглөө.
- **Ажлын нэр:** Соёл амралтын хүрээлэнгийн гадна ба дотор талыг хэсэгчлэн засварлах, стандартын тамхины цэг байгуулах /2020 он/
Гүйцэтгэгч: Даянбайгаль ХХК
Гэрээний дүн: 116.0 сая төгрөг

Зөрчлийн утга: Тамхи татах цэгийн барилга нь битүүмжлэл муу, тоос шороо ихээр орсон, дээврээс ус нэвтэрсэн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Барилгын тухай хуулийн 14.7, Барилга, байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гарсан зөрчлийг арилгах, эвдрэл гэмтлийг засуулах талаар албан шаардлага хүргүүллээ.

Зураг №19 / Тамхины цэгийн шороо тоос орсон байдал/



- Ажлын нэр: 3-р сургуулийн англи хэлний лингафоны кабинетуг тохижуулах /2018 он/
Гүйцэтгэгч: Ай Ти Зон ХХК
Гэрээний дүн: 40.2 сая төгрөг
Зөрчлийн утга: Тухайн ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 2.8 сая төгрөгийн нэг ширхэг проектор тооллогоор дутагдсан байна.
Шийдвэрлэсэн байдал: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6¹⁸ заалтыг хэрэгжүүлж ажиллах, үүссэн нөхцөл байдалд арга хэмжээ авч буруутай этгээдээр нөхөн төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүллээ.



Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй, түүнд тавих хяналт сул, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Цаашид нийтийн эзэмшлийн талбайд хийгдсэн хөрөнгийг өмчлөлд шилжүүлэхдээ байгууллагын онцлог, давуу болон сул тал, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг судлах шаардлагатай байна.

¹⁸ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах



БҮЛЭГ 4. Явган зорчигч, дугуйн зам зураг төсвийн дагуу хийгдсэн байна.

Даланзадгад суманд 2018 онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 665.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Даланзадгад сумын төвд Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн чиглэлд дугуйн болон явган хүний зам барих” ажил, 2019 онд Даланзадгад сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 85.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Даланзадгад сумын гэр хороололд явган хүний замын тоог нэмэгдүүлэх” ажлуудыг гүйцэтгэхээр баталсан байна.

2018 оны үнэлгээний хороог АЗДТГ-ын дарга, 2019 оны үнэлгээний хороог СЗДТГ-ын дарга тус тус томилсон байна.

Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг хангасан байна.



ХАА-г нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэж, 2018 оны ажлын тендер амжилттай болж, 2019 оны ажил эхний удаа амжилтгүй болсноор дахин зарлаж, шалгаруулсан байна.

“Даланзадгад сумын төвд Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн чиглэлд дугуйн болон явган хүний зам барих” ажлын гэрээг 2018 оны 06 дугаар сарын 04-н өдөр 625.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Хомын тал” ХХК-тай байгуулсан байна.



“Даланзадгад сумын гэр хороололд явган хүний замын тоог нэмэгдүүлэх” ажлын гэрээг 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр 79.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Тангад араа” ХХК-тай байгуулсан байна.

Аймгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн “Даланзадгад сумын төвд Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн чиглэлд дугуйн болон явган хүний зам барих” ажил 39.4 сая төгрөг, Даланзадгад сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн “Даланзадгад сумын гэр хороололд явган хүний замын тоог нэмэгдүүлэх” ажил 5.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна. Хийгдсэн хоёр ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авсан байна. Дээрх ажлын гүйцэтгэлийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

Зураг №20 /Анх хүлээж авсан зураг/



Зураг №21 /Одоо буюу 3 жилийн дараах байдал/



Сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн “Даланзадгад сумын гэр хороололд явган хүний замын тоог нэмэгдүүлэх” ажлыг гэрээний хугацаанд хүлээн авсан байна. Дээрх ажлын хүрээнд хийгдсэн 1,3 км явган хүний замыг шалгахад гарсан эвдрэл гэмтэл байхгүй байна.

Зураг №22 /Явган хүний замын одоогийн байдал/



Даланзадгад сум нь дугуйн замын бүтээн байгуулалтыг хийж хэрэгжүүлснээр бусад аймагтай харьцуулахад хамгийн урт дугуйн замтай аймаг болсон байна. Мөн дугуйн спортыг сонирхогч нэмэгдэж “Говь” унадаг дугуйн клуб байгуулагдан ажиллаж байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд “Үндсэн чиглэл 2017-2020”, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна,
- Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхдээ хэрэгцээ, шаардлагаар нь эрэмбэлээгүй байна,
- Төсвийн хөрөнгө оруулалтын ТЭЗҮ, ажлын даалгаврыг үндэслэлтэй боловсруулах шаардлагатай байна,
- Хөрөнгө оруулалтын жагсаалтад зардлын шинж чанартай хөрөнгийг тусгаж батлуулсан байна,
- Тендер сонгон шалгаруулалт зохион байгуулсан хавтаст хэрэг, бичиг баримтын бүрдэл дутуу, хангалтгүй архивлагдсан байна,
- Үнэлгээний хороонд ажилласан иргэний төлөөлөл болох 30 гишүүн нь 3 болон түүнээс олон давтамжтайгаар томилогдсон байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна,
- Гэрээнд заасан хугацааг баримтлан ажиллаагүй хэтэрсэн гүйцэтгэгчид гэрээний заалтын дагуу алданги тооцож ажиллаагүй байна,
- Төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналт сул байна,
- Явган зорчигч, дугуйн замын бүтээн байгуулалтын ажлууд зураг төсвийн дагуу хийгдсэн байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Даланзадгад сумын засаг дарга Х.Батболдод:

1. Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, 2021-2024 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан сумын урт болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөж байх.
2. Үнэлгээний хороонд ажиллах иргэний төлөөллийг сонгохдоо ажил эрхлэлтийн байдал болон бусад нөхцөлийг харгалзан үзэх, нэг иргэний төлөөллийг олон ажилд томилохгүй байх,
3. Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлага болон тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж байх, объект дээр бодит хэмжилт хийх, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа, техникийн нөхцөлийг бодитой тооцож байх,
4. Ажил хүлээлцэх улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавьж байх,
5. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайд хийгдсэн хөрөнгийн шинж байдлыг нь харгалзан хөрөнгөнд бүртгэх байгууллагыг сонгож байх,
6. Хөрөнгийн ашиглалтын байдалд тавих хяналтыг сайжруулан эвдрэл, гэмтэл үүссэн даруйд буруутай этгээдээр засуулах арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл хүргүүлж ажиллах

Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.



Тайлан баталгаажуулсан тушаал



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/22

Даланзадгад

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Даланзадгад сумын 2017-2020 онуудын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт түүний үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Т.Хонгорзул/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦЭРЭНБАЯР



D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2021\А-22.Docx

016010023

